



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 05 сарын 01 өдөр

Дугаар 4/199

Мандалговь

Г Комисс томилох тухай Г

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5/а/, Соёлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.1, Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.1, 16.1.8, 16.1.12, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.4.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Монгол Улсын Гавьяат жүжигчин, Зууны манлай, Алдарт уртын дуучин Ж.Дорждагвын мэндэлсний 115 жилийн ой 2019 онд тохиохтой холбогдуулан "3000 уртын дуучид, морин хуурчид"-ын наадам зохион байгуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай. Үүнд:

Комиссын дарга:	Ж.Мөнхчулуун	Засаг даргын орлогч
Гишүүд:	Ц.Эрдэнэсүрэн	Засаг даргын Тамгын газрын дарга
	М.Цогзолмаа	Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга
	А.Нарантуяа	Нийгмийн бодлогын хэлтсийн дарга
	А.Ганбат	Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
	Н.Эрдэнэ-Очир	Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга
	Б.Түвшинбаяр	Хууль, эрх зүйн хэлтсийн дарга
	Г.Самданцоодол	Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн дарга
	Б.Амаржаргал	Цэргийн штабын дарга
	Ц.Сугиржав	Цагдаагийн газрын дарга
	Н.Гантулга	Байгаль орчин аялал жуулчлалын газрын дарга
	Ж.Батхөлөг	Адаацаг сумын Засаг дарга
	Г.Туяа	Баянжаргалан сумын Засаг дарга
	Б.Доржсүмбэр	Говь-Угтаал сумын Засаг дарга
	Л.Өлзийбат	Гурвансайхан сумын Засаг дарга
	Б.Иш-Ёндон	Дэлгэрцогт сумын Засаг дарга

0200572

О.Батчулуун	Дэлгэрхангай сумын Засаг дарга
Н.Мядагмаа	Дэрэн сумын Засаг дарга
Л.Цогзолмаа	Луус сумын Засаг дарга
А.Эрдэнэбат	Өлзийт сумын Засаг дарга
Л.Мөнхбадрах	Өндөршил сумын Засаг дарга
Б.Түвшинбаатар	Сайхан-Овоо сумын Засаг дарга
Р.Мөнхтогтох	Сайнцагаан сумын Засаг дарга
Ч.Зоригтбаатар	Хулд сумын Засаг дарга
Д.Буджав	Цагаандэлгэр сумын Засаг дарга
С.Мөнхбаатар	Эрдэнэдалай сумын Засаг дарга
М.Болор-Эрдэнэ	Нийгмийн бодлогын хэлтсийн ахлах мэргэжилтэн
Л.Оюунбаяр	Боловсрол, соёл урлагийн газрын боловсрол, соёлын албаны дарга
Д.Доржсүрэн	Төв Халхын дуулалт жүжгийн театрын дарга
А.Ууганбаяр	"Тэнгэрийн тэмдэг" хүүхдийн театрын захирал
М.Бямбажав	Музейн захирал
Ц.Одончимэг	Төв Номын сангийн захирал
Х.Цогзолмаа	Боловсрол, соёл урлагийн газрын мэргэжилтэн
Ж.Дүнжмаа	"Тэнгэрийн тэмдэг" хүүхдийн театрын уртын дууны багш
П.Цолмонтөгс	Төв Халхын дуулалт жүжгийн театрын дууны ангийн багш, дуучин
М.Наранбаатар	Төв Халхын дуулалт жүжгийн театрын морин хуурч
Б.Ням	МХАУТ-ын Дундговь аймаг дахь салбарын тэргүүн
Нарийн бичгийн дарга: Ц.Бумангэрэл	Боловсрол, соёл урлагийн газрын дарга

Хоёр. Монгол ардын уртын дуу "Уяхан замбуу тивийн наран", "Энх мэндийн баяр", "Эр бор харцага", "Цэвцгэр хурдан шарга", морин хуурын аялгуу "Үүлэн бор", "Монгол аялгуу", "Говийн жонон", "Дундговийн магтаал"-ыг нийт иргэддээ зааж сургах ажлыг өрнүүлэн, хуурчдыг морин хуураар хангахад санаачилга гарган ажиллахыг сумдын Засаг дарга, албан байгууллага аж ахуй нэгжийн удирдлагуудад үүрэг болгосугай.

Гурав. "3000 уртын дуучид, морин хуурчид"-ын наадмын бэлтгэл ажлын төлөвлөгөө гарган хэрэгжүүлж, үр дүнтэй зохион байгуулахыг комисс /Ж.Мөнхчулуун/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О. БАТ-ЭРДЭНЭ